



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 6/13

Хэрлэн сум

Ц.Чогсомжавын цалинг  
шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Улсын их хурлын 2019 оны “Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр батлах тухай” 63 дугаар тогтоол, “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” 19 дүгээр тогтоол, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоол, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2021 оны “Тогтоолын заалт хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 398 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоолд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан аймгийн Засаг дарга Ц.Чогсомжавын үндсэн цалинг шинэчлэн тогтоосугай.

2.Аймгийн Засаг дарга Ц.Чогсомжавын үндсэн цалингийн итгэлцүүрийг ТЗ-15-3 шатлалаар тооцож, улс төрийн албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг 30 хувиар олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБААТАР